



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/494

Есөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 32 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цогт сумын Баянтоорой тосгонд 2023 оны 09 дүгээр сарын 07-09-ны өдрүүдэд зохион байгуулагдах “Говийн малчид-2023” малчдын зөвлөгөөн болон “Алтан намар” ургацын баяр зохион байгуулахад 10,000,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Шаардагдах 10,000,000 (арван сая) төгрөгийн зардлыг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР